

● Улсын математикийн II олимпиадын дүнгийн хурал 4 дүгээр сарын 1-нд монголын пионерийн ордонд болов.

Улсын математикийн II олимпиадыг зохион байгуулах хорооны дарга, математикийн ухааны дэд эрдэмтэн Л. Шагдар хурлыг нээж, олимпиадын дүнгийн тухай итгэлийг, зохион байгуулах хорооны орлогч дарга, доцент Санжмятав тавив.

Тус оронд социализмын материал техникийн баазыг амжилттай байгуулж байгаа үед математикийн талаар өндөр мэдлэгтэй боловсон хүчнүүд ихээр шаардагдаж байгаатай уялдуулан дунд сургуулийн математик заалтын байдлыг улам дээшлүүлэхийн чухлыг илтгэгч онцлон тэмдэглээд математикаар сурагчдын дунд зохиох олон хэлбэрийн ажлыг чанартай явуулж байх нь зүйтэй гэв.

Оюун ухааныхаа хурц мэргэнийг сорин үзэлцэх энэ тэмцээний сүүлчийн даваанд аймаг хотуудаас шалгаран ирсэн 32 сурагч оролцож сурагч бүр өдөрт дөрөв дөрвөн бодлого бодсоноос нийслэлийн 10 жилийн 2 дугаар сургуулийн сурагч Оюун 31 оноо авч I байр эзэлж улсын математикийн II олимпиадын аварга боллоо.

Завхан аймгийн С. Ваша 28,5 оноо, Говь-алтай аймгийн Я. Зинамэдэр 26 оноо авч II байр; Нийслэлийн I дүгээр дунд сургуулийн сурагч Д. Билэгт 24 оноо, Баянхонгор аймгийн С. Бумцэнд 23,5 оноо, Нийслэлийн 21 дүгээр сургуулийн сурагч Л. Тогоохүү 23 оноо, Налайх хотын 10 жилийн сургуулийн сурагч Д. Ичинноров 22,5 оноо, Булганы Ч. Лхагважав, Өмнөговийн Содном нар 21 оноо, Дорноговийн Ц. Адьяа 20,5 оноо тус тус авч III байр эзэллээ.

Улсын математикийн II олимпиадад амжилттай оролцсон сурагчид, мөн сурагчдаа олимпиадад сайн бэлтгэж оролцуулсан нийслэлийн 1,2 дугаар сургууль, Завхан, Говь-алтай Баянхонгор аймгийн төвийн 10 жилийн сургууль, Нийслэлийн 2 дугаар сургуулийн багш Янжмаа, Завхан аймгийн төвийн 10 жилийн сургуулийн багш Ламжав, Говь-алтай аймгийн төвийн 10 жилийн сургуулийн багш Монхор, Нийслэлийн 1 дүгээр сургуулийн багш Содном, Баянхонгор аймгийн төвийн 10 жилийн сургуулийн багш Борис нарыг Гэгээрлийн Яам, МХЗЭ-ийн Төв Хороо, Соёл Гэгээрлийн ажилтны Үйлдвэрчний Эвлэлийн Төв Хорооноос диплом, баярын бичиг, үнэ бүхий зүйлээр шагналаа.

Тус хурал дээр Гэгээрлийн Яамны сайд Д. Ишцэрэн улсын математикийн олимпиадыг уламжлал болгон явуулж байгаагийн ач холбогдлыг онцлон тэмдэглэж, олимпиадад сурагчдаа сайн бэлтгэсэн сургууль, багш нарт баяр хүргээд дараачийн олимпиадад улам өндөр амжилт гаргахыг хүсэв.

● Ойгоо тэмдэглэв. Сурган хүмүүжүүлэх ухааны Хүрээлэнгийн 10 жилийн ойг 4 дүгээр сарын 15-нд тэмдэглэж өнгөрүүлэв.

Тус хүрээлэн өнгөрсөн хугацаанд шинэ системийн сургуулийн сургалтын төлөвлөгөө, хичээлийн программыг боловсруулан турших, сурах бичиг, гарын авлага ном зохиох, багш нарын мэргэжлийг дээшлүүлэх, сургалт хүмүүжлийн асуудлаар туршин сорих, судлан боловсруулах ажлыг зохиож иржээ.

Сурган хүмүүжүүлэх Ухааны хүрээлэнгийн 10 жилийн ойг тохиолдуулан тус Хүрээлэнгийн захирал Д. Гомбосүрэн, эрдэм шинжилгээний ажилтан Ж. Гонгоржав, Ц. Өлзийхутаг нарыг «БНМАУ-ын ардын гэгээрлийн тэргүүний ажилтан» тэмдгээр шагнасан байна.